

МОНГОЛЫН ФИЛОСОФИЙН ХОЛБОО

ӨНӨӨГИЙН МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НОМ УНШИХ СОЁЛЫН ХАНДЛАГА

(СОЦИОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН)




УЛААНБААТАР

2022

Тайлан боловсруулсан: М.Золзаяа –Доктор (Ph.D), дэд профессор

Талархал: Судалгааны мэдээлэл цуглуулахад Архангай аймгийн Монголын эмэгтэйчүүдийн холбооны зөвлөл, Архангай аймаг Насан туршийн боловсролын төв, Бурхны шашинт эмэгтэйчүүдийн холбоо, Ховд аймгийн Дарви сумын ЕБС, Нийслэлийн СБД-ийн эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран ажилласанд талархаж байна.



Эх сурвалж: 2021 он. Төв талбайд болж буй Үндэсний номын баяр энэ сарын 13-н хүртэл үргэлжилнэ. <https://ikom.mn/n/28wh.html>

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Тайлангаас ашиглах тохиолдолд гүйцэтгэгч, байгууллага, судалгааны тайлангаас эшилснийг дурдана уу.

ГАРЧИГ

Графикийн жагсаалт.....	4
Судалгааны танилцуулга.....	5
Өнөөгийн монгол эмэгтэй уншигчийн төлөв хандлага.....	7
Номын сонголт.....	9
Номын хүртээмж.....	17
Ном унших арга.....	24
Дүгнэлт.....	34
Ном зүй.....	36

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1.** Ном уншихад нөлөөлдөг субъект
- График 2.** Ном унших сонирхолтой болсон үе
- График 3.** Унших дуртай номын төрөл
- График 4.** Унших дуртай уран зохиолын номын төрөл
- График 5.** Унших номын сонголтод нөлөөлөх хүчин зүйлс
- График 6.** Сонсдог номын хэрэглээ
- График 7.** Ном уншихад аль тохиромжтой цаг
- График 8.** Ном унших таатай орчин
- График 9.** Монголын уран зохиол дахь эмэгтэй хүний дүр
- График 10.** Танд ойролцоогоор хэчнээн ном байдаг вэ?
- График 11.** Шинэ ном, шилдэг номын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?
- График 12.** Та ихэнхдээ хаанаас ном худалдан авдаг вэ?
- График 13.** Та жилд хэдэн төгрөг ном худалдан авахад зарцуулдаг вэ?
- График 14.** Нийтийн номын сангийн байнгын уншигчид
- График 15.** Та хамгийн сүүлд хэзээ номын сангийн (танхим, гэрээр, зөөврийн, цахим) үйлчилгээ авсан бэ?
- График 16.** Номын санд очдог шалтгаан
- График 17.** Сард уншдаг номын тоо
- График 18.** Төлөвлөсөн цагт номоо уншиж чаддаггүй бол юу их нөлөөлж байна вэ?
- График 19.** Номыг үр бүтээлтэй уншихын тулд ямар арга хэрэглэдэг вэ?
- График 20.** Та гадаадын аль орны зохиогчдын ном бүтээлийг унших дуртай вэ?
- График 21.** Уншигчийн хэв маяг
- График 22.** Бусдад ном бэлэглэх үе
- График 23.** Номын соёлын түвшин
- График 24.** Амьдралд нь томоохон өөрчлөлт авчирсан нэг номын төрөл

ТАНИЛЦУУЛГА

2022 оны 03 дугаар сард 18-аас дээш насны эмэгтэйчүүдийн дунд явууллаа. Энэхүү судалгаанд өнөөгийн монгол эмэгтэйчүүдийн ном унших соёлын түвшнийг тодруулахыг зорьсон болно.

Судалгаа явуулсан цаг хугацааны хувьд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээнүүд давхацсан болно.

Тус судалгааны үр дүнгээр эмэгтэйчүүд болон жендер судлал, ном судлал, номын худалдаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжийн практик үйл ажиллагаанд ашиглах санал зөвлөмж боловсруулах боломжтой. Энэ нь ном хэвлэлийн компанийн маркетинг, номын сангийн үйлчилгээг сайжруулах, төрөөс эмэгтэйчүүдийн соёлын талаар баримтлах бодлогод нөлөөлөх ач холбогдолтой гэж найдаж байна.

I. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ТҮҮВРИЙН ТОЙМ

СУИС-ийн СУСХ-ээс “Соёлын үйлчилгээний төлөв байдал” сэдэвт судалгаа хийжээ. Тус судалгааны тайланд иргэдийн насан туршийн боловсролд номын сангийн үйл ажиллагаа чухал үүрэгтэй бөгөөд иргэдийн өөрийгөө тасралгүй хөгжүүлэхэд ном унших хэрэгцээ зайлшгүй. Иймд номын сангийн үйлчилгээ нь насан туршийн боловсролыг дэмжих үйл ажиллагаа гэдгийг онцлон тэмдэглэжээ.¹ Харин монгол эмэгтэй уншигч сэдвээр бие даасан судалгаа хийгдээгүй байна.

Энэ нь эмэгтэйчүүдийн ном унших соёлын төлөвшил, хандлага, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах зорилготой судалгаа юм. Үүнд:

- Номын сонголт
- Номын хүртээмж
- Ном унших арга зэрэг асуудлыг тодруулан авч үзлээ.

Судлагдсан байдал: Монгол эмэгтэйчүүдийн асуудлаар гадаад, дотоодын судлаачдын бүтээл их байна. Жишээ нь,

Швейцарын Хөгжлийн Агентлаг, IRIM судалгааны хүрээлэнгээс 2015 онд “**Монгол дахь жендерийн асуудал**” хэмээх баримт бичгийн судалгаа, Фридрих Эбертийн сангаас 2019 онд “**Монголын эмэгтэйчүүд ба хөдөлмөрийн ирээдүй**”, 2021 онд Ядуурлыг бууруулах Япон сан, АХБ-аас “**Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендерийн дүн шинжилгээ**”, 2021 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс “**Монгол Улсад Ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа-2021**” судалгааг хийж тайланг нийтэлжээ.

Дээрх судалгаануудад эмэгтэйчүүдийн ном унших хандлагын талаар тусгайлсан дүгнэлт, мэдээлэл тусаагүй байгаа юм.

Судалгааны объект: Улаанбаатар, Сэлэнгэ, Сүхбаатар, Баянхонгор аймгийн Баянлиг, Баянцагаан, Дархан-Уул аймаг, Дорноговь, Ховд аймгийн Дарви, Баян-Өлгий, Архангай аймгийн эмэгтэйчүүдийг хамруулсан. Сумдаас 14%, аймгаас 24%, хотоос 62% хамрууллаа.

¹ СУСХ. Соёлын үйлчилгээний хүртээмжийн судалгаа. Тайлан. УБ.,2019. 159 дэх тал.

II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааг социологийн судалгааны арга зүй, аргачлалыг баримтлан явууллаа. Судалгааны мэдээлэл цуглуулахад анкетын асуулгын аргыг ашиглав.

Судалгаанд тоон төлөөлөл (representativity), мэдээллийн үнэн магадтай байдал (validity), мэдээллийн найдвартай чанар (reliability) гэсэн гурван шалгуурыг харгалзаж үзсэн.

Тоон судалгааны арга зүй: Асуулгын арга, судалгааны тоон мэдээлэлд шинжилгээ хийх аргыг ашиглав.

Чанарын судалгааны арга зүй: Баримт бичиг судлах аргаар номын сангийн үйл ажиллагааны тайлан, эрх зүйн акт, статистик мэдээлэл, номын танилцуулгын мэдээлэл, бусад эх сурвалжид дүн шинжилгээ хийсэн.

Мэдээлэл цуглуулах ажлыг 2022 оны 3 дугаар сараас 3 дугаар сарын 22-ны хооронд явуулсан.

Түүврийн тодорхойлолт: Үндэсний статистикийн мэдээллийн 2020 оны нийтийн номын сангийн уншигчдын 277061, нийт хүн амын дунд 18-аас дээш насны 1146995 эмэгтэйчүүд гэсэн тоог түүврийн эх олонлогоор сонгож, түүврийн хэмжээг гаргасан алдааны хувийг 4.97-аар тооцсон.

Нийтийн номын санд уншигчдын статистик үзүүлэлт тооцож гаргаж буй ч 1500 орчим номын сан тус бүрийн уншигчийн статистик, тайлан ил биш байна.

Судалгаанд 317 респондент хамрагдсан нь төлөөллийн шаардлагыг хангаж чадсан гэж үзэж байна. Судалгааны зорилтот бүлэг нь 18-аас дээш нас, уншигч байхыг үндсэн шалгуур болгож авлаа. Судалгаанд хамрагдагчдын дотор 35 хүртэл насны залуучууд 45%, 36-55 насныхан 51%, 55-аас дээш насныхан 4 хувийг эзэлж байна.

2021 оны байдлаар Монгол Улсын хүн ам 3,409,939, үүнээс 1,735,882 нь эмэгтэйчүүд эзэлж байна. Их дээд сургууль, коллежид суралцагчдын 61% нь эмэгтэйчүүд байна.

Эмэгтэйчүүдийн боловсрол нь тэдний чөлөөт цагийн соёлд маш их нөлөөтэй бөгөөд ялангуяа ном уншиж өөрийгөө хөгжүүлэх, улмаар үр хүүхдээ зөв хүмүүжүүлэх арга зам болно.

Судалгаанд хамрагдагсдын 80% нь дээд, 4% тусгай дунд, 16% бүрэн дунд боловсролтой. Энэ судалгаа нь интернэтийн хэрэглэгч байхыг шаардаж буйгаараа онцлог болно. Судалгаанд оролцогчдын 49.8% нь төрийн алба, 19.6 хувь нь оюутан, 6.9% нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 6.3% нь бизнесийн салбарт, 4.4% нь судлаач, 6.3%, тэтгэвэрт 2.8%, 2.5% нь гэрээт ажилтан бусад буюу их сургуулийн багш, ТӨҮГ-ын ажилтан, ОУБ, ТББ, Сүм хийдэд алба хашдаг байна.

Судалгааны ёс зүй: Судалгаанд оролцсон эмэгтэйчүүдэд судалгааны үр дүнг эрдэм шинжилгээний зориулалтаар ашиглахыг урьдчилан танилцуулж, судалгаанд оролцох эсэх сонголтыг өөрөө хийсэн. Онлайн судалгаа учир оролцогч өөрөө судалгаанд хариулах эсэхээ шийдэх давуу талтай. Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд чанарыг эрхэмлэх, судалгаагаар илэрсэн баримтыг гуйвуулахгүйгээр бодит байдлыг тайлбарлахад ашигласан болно.

ӨНӨӨГИЙН МОНГОЛ ЭМЭГТЭЙ УНШИГЧИЙН ТӨЛӨВ ХАНДЛАГА

XX зууны эхэн үеийн монголын эмэгтэйчүүд мал маллах, гэр орны ажил хийхийн зэрэгцээ үр хүүхдээ эрүүл саруул өсгөж, хүмүүжүүлэх чадварыг гарамгай эзэмшсэн хэдий ч цөөн тооны язгууртан, баячуудын охид, хатдыг эс тооцвол толгой дараалан бичиг үсэг мэдэхгүй байлаа.

1920-иод оны эхэн үеэс эмэгтэйчүүдийн бичиг үсэг тайлагдах, боловсрол, мэргэжил олгох талаар монголын төрөөс ихээхэн анхаарчээ. 1929 онд гадаад, дотоодын бүх сургуульд суралцагсдын 30-аас доошгүй хувийг эмэгтэйчүүд эзэлж байхаар тогтоосон. 1960-аад оны үеэс охидыг бүрэн дунд боловсролтой болгох, мэргэжлийн сургуульд суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилт тавьсан. 1970-аад оны үед эмэгтэй суралцагчдын 49.8 хувь нь дээд, 59.4 хувь нь тусгай дунд, 52.8 хувь нь техник мэргэжлийн сургууль, 49.7 хувь нь дунд сургуульд суралцаж байжээ. Харин Нийтийн номын сангийн тоо 1950 онд 22, 1960 онд 33, 1965 онд 343, 1970 онд 425, 1971 онд 451 болж байжээ. Мөн номын фонд 5,3 сая хүртэл өссөн.² Эмэгтэйчүүдийн боловсрол нь тэдний чөлөөт цагийн соёлд маш их нөлөөтэй бөгөөд ялангуяа ном уншиж өөрийгөө хөгжүүлэх, улмаар үр хүүхдээ зөв хүмүүжүүлэх арга зам болно. Энэ асуудлын хүрээнд социализмын үед хамаарах дараах хэдэн мэдээллээс харж болно.

1980 оны эмэгтэйчүүд сэтгүүлийн “Соёлч зөвлөл” буланд “Архангай аймгийн Хүнсний үйлдвэрийн ажилчдын 60 гаруй хувь нь эмэгтэйчүүд, тэдний 90 гаруй хувь дээд, дунд, тусгай мэргэжлийн сургууль төгссөн байсан.



Эмэгтэйчүүдэд эрүүл мэнд, хүүхдийн хүмүүжил, ахуйн соёлжилттой холбогдсон асуудлаар лекц яриаг тогтмол хийж, хүүхэд хөхүүлэх байрыг шинээр тохижуулсан”³ гэж тэмдэглэжээ. Мөн сэтгүүлд шог зураач Ц.Байдын нэгэн зураг нийтлэгдсэн нь эмэгтэй хүн ба номтой холбоотой өгүүлэмжтэй байх нь анхаарал татлаа.

Зураг 1. Ц.Байды “Эгчийн ааш хувирсан нь” 1980 он.

МУИС-ийн багш дэд эрдэмтэн Э.Чимэдцэрэн “1923 оноос төрийн байгууллагад эмэгтэйчүүдийг сонгож нам, аж ахуй, соёлын байгууллагад тэгш эрхтэй ажиллуулж эхэлсэн. Одоо боловсролтой бүх хүний 50 шахам хувь, шинжлэх ухааны салбарт ажиллагсдын 37 хувь эмэгтэйчүүд эзэлж, гавьяат багш


² Пунсалдулам Б. Шинэ соёл Монголд төлөвшсөн түүх. Ред. Болдбаатар Ж. УБ., 2018. 226 дахь тал.

³ Соёлч зөвлөл. Монголын эмэгтэйчүүд сэтгүүл. 1980 оны дугаарт.

НОМЫН СОНГОЛТ


Таныг ном уншихад хэн илүү нөлөөлдөг вэ? гэсэн асуултад 28.4 хувь, 22.1 хувь найз нөхөд, 8.5 хувь хамт олон, 8.2 хувь багш гэж хариулжээ. Энэ нь ном унших сонирхлыг өдөөгч, чиглүүлэгч нь ойр дотнын хүмүүс байдаг, нөгөө талаар монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн уламжлал ямар чухал болохыг харуулж байна.

График 1. Ном уншихад нөлөөлдөг субъект




Бичиг үсэг тайлагдаад ном унших үйл явцад татагдана. ЕБС-ийн уран зохиолын хичээл ном унших сонирхолд маш их нөлөөлдөг бөгөөд суралцагчдын дунд “бүтээлч уншигч”, “хурдан уншигч”, “сайн яригч”, “уран яруу уншигч”, “үр дүнтэй уншигч”, “сонсдог ном уншигч”, “дижитал ном уншигч”, “бусдыг дагуулан уншигч”, “номын утга санааг түгээн дэлгэрүүлэгч” гэх мэт уралдаанаар уншигчийг тодруулах ажиллагаа явуулах, зохиолч уншигчдын уулзалт ярилцлага хийх, уламжлалаа сэргээж “Номын сайн нөхөр” тэмдэгтэн төрүүлэх арга хэмжээ зохиодог. Тэгэхээр эмэгтэйчүүд хэдэн настайдаа ном унших сонирхол, дадалтай болдог вэ? гэдгийг тодруулж үзлээ. Нийт хариултын 50 хувь буюу 15 хүртэл нас, 26 хувь нь 15-20 наснаас ном унших сонирхолд хөтлөгдсөн гэж хариулжээ.

График 2. Ном унших сонирхолтой болсон үе




Судалгаанд оролцогчдын унших дуртай номын төрлүүдээс 3-ыг сонгуулахад 21.3 хувь нь уран зохиол, 16.5 хувь нь хувь хүний хөгжил, 8.7 хувь нь шинжлэх ухааны номыг нэрлэжээ. Нийт оролцогчдын 8.7 хувь нь шинжлэх ухааны ном унших дуртай гэсэн нь дээд боловсролтой оролцогчид 80 хувийг эзэлснээс хамаарч буй. ЕБС-д уран зохиолын хичээлээр болон суралцагчдын заавал унших номын жагсаалтын дагуу монголын болон сонгодог зохиолчдын бүтээлтэй танилцдаг нь уншсан номын сонголтод ч нөлөөлсөн байж болно.

График 3. Унших дуртай номын төрөл




Судалгаанд оролцогчдын 21.3 хувь нь уран зохиолын номд дуртай. Тэд уран зохиолын номын төрлөөс роман, тууж, богино өгүүллэг, дэлхийн сонгодог уран зохиолыг илүү их сонирхдог байна. Тухайлбал, монгол хэлнээ орчуулагдсан Н.Гоголь, Жек Лондон, Майн Рид, Г.Маркес, А.Дюма, Габриэл Верн Жюль, Марк Твейн зэрэг дэлхийн алдарт зохиолчдын бүтээл үнэ цэнтэйд тооцогддог болох нь харагдаж буй юм. Унших дуртай номын төрлөөс 2-ыг сонгуулахад роман унших дуртай хүний тоо 33.6 хувь буюу бусдаас илүү байна. Сүүлийн үед роман уншигчдын тоо буурсан гэж ярьдаг ч хэвлэлтийн хувьд төдий л буураагүй нь ажиглагдаж байна.

График 4. Унших дуртай уран зохиолын номын төрөл



Уншигчийн сонголтод нөлөөлж буй объектив, субъектив хүчин зүйлсийг тодруулж асуухад өөрөө ном унших хоббитой, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээ, эрхэлж буй ажил, мэргэжил хамгийн их нөлөөлдөг гэсэн (график 5). Эмэгтэйчүүд номын хавтас, дизайн дунд зэргийн хэмжээнд нөлөөлдөг гэж хариулжээ. Ер нь эмэгтэй хүний тухай номын хавтас илүү гоёмсог, өнөө цагийн эмэгтэйг дүрсэлсэн нь ажиглагдаж байна. Мөн номын олон нийтэд үнэлэгдсэн байдал, мэдээлэл сурталчилгаа, уншигчийн чөлөөт цаг нэлээд нөлөөлдөг байна. Харин сонголтод нь номын үнэ, зохиолчийн нэр хүнд төдий л хамаардаггүй аж.

График 5. Унших номын сонголтод нөлөөлөх хүчин зүйлс



Та ямар хэлбэрийн номыг сонгож байна вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 71 хувь буюу дийлэнх олонх нь хэвлэмэл номыг сонгож буй юм. Хэвлэмэл ном нь олонх уншигчийн эрэлт хэрэгцээнд нийцэж, тэдэнд цаасан номын хуудсыг эргүүлж, цаасыг мэдрэх боломж олгон сэтгэгдэл төрүүлдэг. Ном унших дуртай хүмүүс бүх насаараа унших эсвэл үр хүүхдэдээ ч уншуулах номыг сонгодог гэдэг. Судалгаанд оролцогчдын 7 хувь нь цахим ном, 1 хувь нь сонсдог ном, 21 хувь нь дээрх бүгд гэж хариулжээ.

Уншихын ач холбогдол: Унших өнөөгийн хүний сурч болох хамгийн чухал суурь чадварын нэг юм. Ер нь ном унших нь нийгэмтэй харилцах, оролцох чадвартай болоход чухал үүрэгтэй. Энэ нь замын тэмдэг, эмнэлгийн заавар, мэдээ уншихад шаардлагатай. Нэмж дурдахад онлайн-аар эсвэл ном, сэтгүүлээс

мэдээлэл авах нь хүмүүсийг хүрээлэн буй ертөнцийн талаар мэдлэгтэй, мэдээлэлтэй байлгахад тусалдаг. Хүний тархи байнгын хөгжил шаарддаг бөгөөд унших нь туслах үйл ажиллагаа юм. Унших нь хүмүүст илүү идэвхтэй төсөөллийг бий болгоход тусалдаг ба бүтээлч байдлын өндөр түвшинд хүргэдэг.

Өнөө цагт цахим болон хэвлэмэл, сонсдог номыг өргөн хэрэглэж байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд цахим ном нь хэвлэлийн салбарын гол бүтээгдэхүүн болсон. Гэсэн хэдий ч цахим ном нэвтэрсний үр дүнд хэвлэмэл ном устана гэж урьдчилан таамаглаж байсан шиг биелээгүй байна. Америкийн Хэвлэн нийтлэгчдийн холбооны мэдээлснээр, АНУ-д цахим номын борлуулалт 2019 онд өмнөх оны мөн үеэс бага зэрэг буурч, 983 сая доллар болжээ. Цахим номын борлуулалт хэдэн жилийн турш хоёр оронтой тоогоор буурсны дараа өсөлтийн хурд багассан. Хатуу хавтастай болон цаасан хавтастай ном зах зээлд тэргүүлсэн хэвээр байгаа бөгөөд 2019 онд ойролцоогоор 2.5-3 тэрбум долларын борлуулалт хийсэн байна. 2020 оны COVID-19 тахал нь хэвлэлд ашигтай байсан. Хэвлэлийн салбарын "Printing Impressions" сэтгүүлийн мэдээлснээр борлуулалт жилээс жилд 8.2 хувиар өсөж, нийт 751 сая хувь болсон байна. Чөлөөт цагийг гэртээ өнгөрүүлэх, гэртээ ажиллаж, сурах хэрэгцээ нь ном худалдаж авах шалтгаан болсон гэж үзжээ.

Цахим ном нь цаасан номоос хямд биш. Онлайн номын худалдаа эрхэлдэг хэвлэн нийтлэгчид цахим номынхоо үнийг өсгөхөд хүрсэн бөгөөд нэг цахим номын үнийг дунджаар 5 доллароор өсгөжээ. Ашгийн бус төсөл Гутенберг нь 60,000 үнэгүй татаж авах боломжтой ном санал болгодог бөгөөд тэдгээрийн ихэнх нь зохиогчийн эрхийн баталгааны хугацаа нь дууссан сонгодог ном. Үнэгүй сонгодог номууд нь Алкотт, М.Луиза, П.Г.Вудехаус хүртэлх цагаан толгойн үсгийн жагсаалтад яг ийм зүйлийг санал болгодог. Google Books нь сурах бичиг, засгийн газрын баримт бичиг, уран зохиолын сонгодог зохиол зэрэг 10 сая гаруй номыг үнэгүй татаж авах боломжтой гэдгээрээ сайрхдаг.⁶

Цахим ном нь хуудсыг гүйлгэн үзэх явцад ахиц дэвшлийг нь харах бололцоотой. Цаг хугацаа хэмнэсэн сонсдог номыг гэртээ амрах үед, их хотын замын түгжрэлд орох үед сонсож байна гэж хариулжээ.

График 6. Сонсдог номын хэрэглээ



⁶ E-Books vs. Print Books: What's the Difference? <https://www.investopedia.com/financial-edge/0812/e-books-vs.-print-books.aspx>.

Манай судалгаанд оролцогчдын 71 хувь буюу дийлэнх олонх нь хэвлэмэл номыг сонгож буй юм. Хэвлэмэл ном нь олон уншигчдын дуртай ном шиг сэтгэгдэл төрүүлдэг. Зарим уншигч хэвлэсэн номын оронд электрон төхөөрөмж ашигласнаас нүд нь ядаргаатай болж байна. Та үүнийг барьж, хуудсыг эргүүлж, цаасыг мэдрэх боломжтой. Ном унших дуртай хүмүүс бүх насаараа унших эсвэл үр хүүхдэдээ ч уншуулах номыг сонгоно.

Хэвлэх ном нь цахим номоос арай илүү үнэтэй хэвээр байгаа ч тийм ч их биш. Ерөнхийлөгч Барак Обамагийн **“Promised Land-Зорьсон газар дэлхий”** хэмээх дурсамж ном нь Kindle хэвлэл 17,99 ам.доллар, хатуу хавтастай нь 23,96 ам.долларын үнэтэй байна. Жон Гришамын өмнөх бестселлер болох The Guardians киноны Kindle хувилбар нь 9,99 ам.доллар, цаасан хавтастай нь 9,64 ам.доллар, хатуу хавтастай нь 14 ам.долларын үнэтэй.

Дэлхийн олон оронд цахим, сонсдог номын хэрэглээ өсөж байна. Монгол Улсын нийт хүн амын 90 хувь нь ухаалаг утас хэрэглэж, гурван хүн тутмын нэг нь сошиал сүлжээг идэвхтэй ашигладаг. Эндээс манай улсад ч бас цахим номын зах зээл хөгжих боломж байгаа нь харагдаж байна. Монголд одоогоор M plus, E-san зэрэг онлайн номын худалдаа эрхэлдэг компаниуд үйл ажиллагаа явуулж байна. Иймд судалгаанд оролцогчдоос “Та сонсдог номыг ямар үед сонсож байна вэ? (гол гэсэн 2-ыг сонгоно уу)” гэж асуухад 15.0 хувь нь сонсдог номыг сонгодоггүй гэж хариулсан бөгөөд 25.1 хувь нь гэртээ амрах, 18.9 хувь нь замын түгжрэлийн үед ном сонсдог гэж хариулжээ. Үлдсэн 2.5 хувь нь “Хөдөө орон нутагт сонсдог ном олдоц муутай, Хол замд, Өглөө орондоо, Цаг өнгөрөөхийн тулд, Анхаарал сарниулдаг гэж үздэг” гэж хариулжээ.

Дараагийн чухал асуудал бол эмэгтэйчүүдийн ном унших чөлөөт цагийн боломжийн тухай юм.

Үндэсний Статистикийн Хороо “Цаг ашиглалтын судалгаа”-г дөрвөн жил тутамд нэг удаа хийдэг. Сүүлд энэ судалгааг 2019 онд хийжээ. Цаг ашиглалтын судалгаанд 4,000 өрхийг судалгаанд хамруулж, 3,972 өрхөд нийт 13,627 хүн амьдарч байв. Үүнээс 49.2 хувь нь эрэгтэй, 50.8 хувь нь эмэгтэй байлаа. Эрэгтэйчүүд ном, сонин унших, радио сонсох, телевиз үзэх, компьютер, утас ашиглах, интернэтэд орох зэрэг ажилд өдрийн нийт цагийнхаа 9.0 хувь буюу 130 минутыг зарцуулдаг бол эмэгтэйчүүд 7.4 хувь буюу 107 минутыг зарцуулж байв. Харин хүүхэд, залуучууд энэ үйл ажиллагаанд өдөрт 2-оос дээш цагийг зарцуулдаг.⁷ Тиймээс эмэгтэйчүүдийн өдөрт ном сонин унших цаг эрэгтэйчүүдээс 23 минутаар бага байна


Ном уншихад тогтмол цаг зав гарган унших хэрэгтэй. Эхний ээлжид ном унших цагийн хуваарьтай болж тогтсон цагтаа номоо барьж аваад заавал уншдаг байх шаардлагатай болдог. Монгол Улсын 12, түүнээс дээш насны нийт хүн амын 39 хувь нь 7-8 цагийн хооронд, харин 88 хувь нь 23-24 цагийн хооронд унтаж байна. Судалгааны үр дүнгээс харахад өглөө 5 хүн тутмын 1 нь 7-8, 2 нь 8-9, 1 нь 9-10 цагийн хооронд сэрдэг байна. Харин орой 21-22 цагийн хооронд

⁷ Монголчууд хоногт дунджаар 9.2 цаг унтаж, 3.3 цаг ажил хийж, 6 минут спортоор хичээллэж байна. <https://ikon.mn/n/1yif>. 2022.03.26.

5 хүн тутмын 1 нь, 22-23 цагийн хооронд 5 хүн тутмын 3 нь 23-24 цагийн хооронд 10 хүн тутмын 9 нь унтаж байв. Хүн амын дийлэнх хэсэг нь өдрийн хоолыг 12-14 цагийн хооронд харин оройн хоолыг 18-21 цагийн хооронд иддэг байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг 20-22 цагийн хооронд хэрэглэж буй хүн ам хамгийн их байлаа.⁸ Харин судалгаанд оролцогч эмэгтэйчүүд гэрийн ажил хийх, хүүхдээ унтуулах, хичээл давтуулах ажил дууссаны дараа буюу оройн цагаар ном уншихад тохиромжтой болдог байна. Оюутан залуучуудын хувьд өглөөгүүр ном уншихад тохиромжтой байна. Өөртөө цаг гаргаж ном унших дадал суулгахыг хичээдэг.

Номын хуудасны тоо янз бүр ч идэвхтэй уншигчид номыг заавал бүтэн уншихыг чухалчилдаггүй. Харин номын гол агуулгыг ойлгож өөрт хэрэгтэй зүйлээ олж харах гэж уншдаг. Номын тэмдэглэлдээ номоос хэрэгтэй санаагаа олж авсны дараа буулгадаг. Ном их уншдаг хүмүүс цаг төлөвлөлт сайтай байдаг. Өдөрт нэг цагийг ном уншихад зарцуулбал жилийн 365 өдөрт тогтмол нэг цагийг ном уншихад зарцуулна. Цаг төлөвлөлтийн тухайд бусад зүйлд сатаарахгүйгээр өдрийн хамгийн тайван амгалан нөхцөлд ном уншихыг илүүд үздэг.


График 7. Ном уншихад аль тохиромжтой цаг



Эмэгтэйчүүд нам гүм чимээгүй орчин, гэртээ ном уншихад илүү таатай гэж үзсэн байна. Оюутнуудын хувьд номын санд унших нь илүү тааламжтай. Судалгаанд оролцогчдын цөөн буюу 2.2 хувь нь “Тээврийн хэрэгслээр зорчих, Орчин хамаагүй, Замд явж байх үед, Чимээгүй бол бүх газарт, Машины түгжрэл, Жаахан цаг гарвал” зэргээр хариулж бичсэн байна. Төрийн үйлчилгээний байгууллагад ажилладаг 21-26 настай нэгэн оролцогч “*Бүх ажлаа амжуулаад сайхан тухтай унших кайфтай, өвдсөн үедээ мөн их ном уншдаг*” хэмээн онцолжээ. Сүүлийн үед кофе шопууд олноор байгуулагдаж, ном унших бололцоо бүрдүүлэн үйлчлэх болсон ч хэрэглэгчийн таатай орчинд төдий л ороогүй байна.


⁸ УСХ. Цаг ашиглалтын судалгаа. Үндсэн тайлан. УБ., 2020. 8 дахь тал.

График 8. Ном унших таатай орчин




Таны бодлоор өнөөгийн Монголын уран зохиолд ихэвчлэн ямар эмэгтэйг дүрсэлдэг вэ? (гол гэсэн 2-ыг сонгоно уу) гэсэн асуултад 30.2 хувь нь ухаалаг, 26.4 хувь нь хөдөлмөрч, бүтээлч эмэгтэйн дүрийг хамгийн их хувиар сонгожээ, 20.1 хувь нь үзэсгэлэнтэй эмэгтэйг дүрсэлдэг гэж хариулсан байна. Номын бүх дүр эерэг биш боловч, ерөнхий агуулгаар уншигчдад үлгэр дуурайл үзүүлэх сургамжтай дүр байдаг гэж хүлээн авдаг болов уу гэсэн сэтгэгдэл төрүүлж байна.

График 9. Монголын уран зохиол дахь эмэгтэй хүний дүр



Судалгаанд оролцогчдын хувийн номын соёл, хэрэглээний тухай тодруулах үүднээс өөрийнх нь номын тоог асуухад 31 хувь нь 70-100 номтой гэж хариулсан байна.

График 10. Танд ойролцоогоор хэчнээн ном байдаг вэ?



Шинэ ном, шилдэг номын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ? гэсэн асуултад хамгийн түгээмэл 2 мэдээллийн сувгийг нэрлүүлэхэд 33.1 хувь нь мэдээллийг нүүр ном, жиргээнээс, 17.1 хувь нь найз нөхдөөс авдаг гэсэн хариултыг өгсөн байна.

Учир нь Монгол Улсын нийт хүн амын 68 хувь буюу 2'200'000 хүн Facebook идэвхтэй ашиглаж, тэдний 99 хувь нь гар утаснаасаа ханддаг юм байна. Түүнчлэн 250'000 хүн Facebook бизнес хуудас удирддаг, 18-34 насны залуучууд социал медиад хамгийн идэвхтэй байдаг ч сүүлийн 2 жилийн судалгааг харвал 45-аас дээш насны Facebook хэрэглэгчдийн тоо тогтвортой өсөж байна. Хүмүүс социал медиаг чөлөөт цагаараа сонирхолтой мэдээ мэдээлэл авах, хүмүүстэй холбоотой байх мөн өөрийгөө олон нийтэд танилцуулах суваг хэмээн харж байна.⁹

Монгол Улсад Facebook хэрэглэгч 2,469,000 хүн байдаг. Тэдний ихэнх нь буюу 52.6 хувь нь эмэгтэйчүүд, 47.4 хувь нь эрэгтэйчүүд. Насны хувьд 25-аас 34 хүртэлх насныхан хамгийн олон буюу 760 мянга орчим аж.


⁹ Facebook хэрэглээ Монголд 2021: https://nathouse.mn/social_media/288.

График 11. Шинэ ном, шилдэг номын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?



Сүүлийн үед социал сүлжээнд ном сонирхдог, уншихыг хүсдэг хүмүүс групп үүсгэн нэгдэж, ном солилцох, бие биедээ танилцуулах зэргээр номын соёлыг сурталчилдаг болсон. Мөн төрөл бүрийн цахим номын сан бий болоод буй. Шинэ ном, уншсан номын тухай ярилцдаг подкастууд бий болсон бөгөөд залуучууд маш их сонирхох болсон. Жишээ нь, Г.Беридэмийн хөтөлдөг 119000 дагагчтай “Bunii University” подкаст сувгийн 2022 оны 2-р сарын 19-ний өдөр “Өөхний тухай яриа” номын талаар танилцуулга хийхэд 117,851 хүн үзэж, 142 коммент бичжээ. Сэтгэгдлүүдийнх нь агуулга ихэвчлэн сайшаасан бөгөөд үүнд 60 орчим эмэгтэй сэтгэгдлээ бичиж үлдээжээ.¹⁰

График 12. Та ихэнхдээ хаанаас ном худалдан авдаг вэ?



¹⁰ Өөхний тухай хамгийн сонирхолтой яриа. <https://www.youtube.com/watch?v=TFgpPYjCik0>.

Үндэсний Статистикийн Хорооноос 2020 оны нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын дүнг танилцуулснаар өрхийн дундаж орлого **1.5 сая** төгрөг. Судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь жилд 30-110000 төгрөгийн ном худалдан авдаг байна. Нийт оролцогчдын **48.6 хувь** нь номын дэлгүүрээс ном худалдан авдаг байна.

График 13. Та жилд хэдэн төгрөг ном худалдан авахад зарцуулдаг вэ?



“Мирим Консалтант” компанийн төслийн баг “3000-5000 хувь борлогдох 100 ширхэг номын жагсаалт” судалгааг хийжээ. Уг судалгаанаас үзэхэд Монгол Улсад жилд дунджаар 750-900 мянган ном борлуулагддаг. Энэ нь өдөрт дунджаар нэг номын дэлгүүрт 50-100 ширхэг ном зарагддаг гэсэн үг юм. Ном товхимол хэвлэлийн салбарт идэвхтэй үйл ажиллагаа эрхэлдэг 150 орчим үйлдвэр, хэвлэлийн компани, номын дэлгүүр байна. Тэдгээрээр үйлчлүүлдэг залуучууд хувь хүний хөгжлийн тухай номуудыг илүү сонирхож, эцэг эхчүүд бага насны хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх, үлгэрийн зурагт номуудыг ихэвчлэн худалдан авдаг.

Монголчууд худалдан авах номоо төдийлөн сайн судалдаггүй. Судалж худалдан авдаг нь маш цөөн. Ихэвчлэн олны танил хүмүүсийн санал болгосон болон тэдний уншиж буй номыг унших, дуурайх хандлагатай байдаг. Мөн номын дэлгүүрийн бестселлер тавиур дээрх номууд худалдан авалтад чамгүй их нөлөөлдөг байна. Гэвч бестселлер номын жагсаалт номын дэлгүүр бүрт харилцан адилгүй байдаг. Тухайлбал, салбар дэлгүүртэй том компани 7 хоногт салбарын хэмжээнд хамгийн их борлуулалттай номыг бестселлер болгон зарладаг бол Мажестик дэлгүүрт 14 хоногт 150 ширхгээс дээш борлуулалттай номыг бестселлер хэмээн үздэг байна.

Үүнээс гадна номын агуулга, чанар, зохиолчийн нэр хүнд ч багагүй нөлөө үзүүлэх нь бий. Олонд танигдсан зохиолч болон хэвлэлийн компанийн бүтээлийг авах хүлээлт хүмүүст аль хэдийн үүссэн байна.¹¹

Манай улсад үйл ажиллагаа явуулдаг 362 нийтийн номын сан, Их дээд сургууль, коллежийн номын сан, ШУА-ийн номын сан, Аймаг сумдын нийтийн номын сан, Улаанбаатар хотын номын сан, Хүүхдийн номын сан, Үндэсний номын сан гээд 1500 орчим номын сан байна. Эдгээрийн номын сангуудын үйл ажиллагаа, үйлчилгээний орчин харилцан адилгүй. Тухайлбал, Төв аймгийн Нийтийн номын сан анх 1944 онд олон түмэнд ном хэвлэлээр үйлчлэх үйл ажиллагаагаа эхэлж 1990 оноос нэг ээлждээ 120 хүн хүлээн авах, 100000 ном байрлуулах хүчин чадалтай зориулалтын байранд шилжин орж үйл ажиллагаагаа явуулж байсан. Сан хөмрөгтөө 34435 ширхэг ном, хэвлэл мэдээллийн материалтай. Уншигч хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд тулгуурлан уламжлалт болон орчин үеийн үйлчилгээг хослуулан 10 төрлийн үйлчилгээг хүргэж байсан юм. Жилд дунджаар 4000 орчим байнгын уншигч 15000 орчим үйлчлүүлэгчид 42000 гаруй ном хэвлэл мэдээллийн материал олгодог. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 27 сумын Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, МСҮТ-ийн номын сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх талаар анхааран ажиллаж байна.

Үүнээс гадна номын агуулга, чанар, зохиолчийн нэр хүнд ч багагүй нөлөө үзүүлэх нь бий. Олонд танигдсан зохиолч болон хэвлэлийн компанийн бүтээлийг авах хүлээлт хүмүүст аль хэдийн үүссэн байна.¹²


Манай улсад үйл ажиллагаа явуулдаг 362 нийтийн номын сан, Их дээд сургууль, коллежийн номын сан, ШУА-ийн номын сан, Аймаг сумдын нийтийн номын сан, Улаанбаатар хотын номын сан, Хүүхдийн номын сан, Үндэсний номын сан гээд 1500 орчим номын сан байна. Эдгээрийн номын сангуудын үйл ажиллагаа, орчин харилцан адилгүй. Тухайлбал, Төв аймгийн Нийтийн номын сан анх 1944 онд олон түмэнд ном хэвлэлээр үйлчлэх үйл ажиллагаагаа эхэлж 1990 оноос нэг ээлждээ 120 хүн хүлээн авах, 100000 ном байрлуулах хүчин чадалтай зориулалтын байранд шилжин орж үйл ажиллагаагаа явуулж байсан. Сан хөмрөгтөө 34435 ширхэг ном, хэвлэл мэдээллийн материалтай. Уншигч хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд тулгуурлан уламжлалт болон орчин үеийн үйлчилгээг хослуулан 10 төрлийн үйлчилгээг хүргэж байсан юм. Жилд дунджаар 4000 орчим байнгын уншигч 15000 орчим үйлчлүүлэгчид 42000 гаруй ном хэвлэл мэдээллийн материал олгодог. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 27 сумын Ерөнхий боловсролын сургууль, Соёлын төв, МСҮТ-ийн номын

¹¹ Монголчуудын өрхийн орлого нэмэгдэх тусам ном худалдан авах нь ихсэж байна. <https://peak.mn/news/sudalgaa-mongolchuudiiin-urkhiin-orlogo-nemegdekh-tusam-nom-khudaldan-awakh-ni-ikhsej-baina>. 2021.02.24.

¹² Монголчуудын өрхийн орлого нэмэгдэх тусам ном худалдан авах нь ихсэж байна. <https://peak.mn/news/sudalgaa-mongolchuudiiin-urkhiin-orlogo-nemegdekh-tusam-nom-khudaldan-awakh-ni-ikhsej-baina>. 2021.02.24.

сангуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх талаар анхааран ажиллаж байна.

График 14. Нийтийн номын сангийн байнгын уншигчид



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны мэдээллийн нэгдсэн сан

Хүснэгт 1. Нийтийн номын сангийн тоо /2018-2020 он/


он	Улаанбаатар	Хангайн бүс	Зүүн бүс	Баруун бүс	Төвийн бүс
2018	10	10	50	94	101
2019	12	107	50	94	101
2020	13	106	50	94	102

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хорооны мэдээллийн нэгдсэн сан

Олон Улсын Номын Сангийн Холбоо (ИФЛА), ЮНЕСКО-гоос гаргасан “Нийтийн номын сангийн үйлчилгээ”-ний удирдамжид “Номын сангаас үйлчилгээ үзүүлэх, асуудлыг амжилттай шийдвэрлэх гол нөхцөлүүдийн нэг нь бодит хүртээмж юм” гэж үйлчилгээний хүртээмжийн ач холбогдлыг онцолсон байдаг. Иймээс үйлчилгээний хүртээмж номын сангаас үзүүлж буй үйлчилгээг уншигч авч чадаж байгаа эсэхээр илэрхийлэгддэг. Монгол улсад нэг жилд дунджаар 14500 нэрийн ном хэвлэгддэг. Гэвч Үндэсний номын сан 700 орчим нэрийн номыг нь л худалдан авч чаддаг аж. Үндэсний хэмжээний номын сангийн гол үүрэг нь тухайн оронд хэвлэгдэн гарч буй бүх ном, бүтээлүүд хадгалагдах ёстой ч Үндэсний номын санд тийм боломж нь хараахан бүрдээгүй байна.

Судалгаанд оролцогчдын 12.3 хувь нь 2019 оноос өмнө номын сангаар үйлчлүүлсэн бол 56 хувь нь сүүлийн 6-р сард танхим, гэрээр, зөөврийн, цахим аль нэг хэлбэрээр номын сангийн үйлчилгээ авсан гэж хариулжээ.


График 15. Та хамгийн сүүлд хэзээ номын сангийн (танхим, гэрээр, зөөврийн, цахим) үйлчилгээ авсан бэ?



Уншигчид номын санд очих шалтгаан янз бүр байдаг. Хамгийн гол шалтгаан бол 24.8 хувь нь ном унших таатай орчин гэж хүлээж авдаг бөгөөд 19.3 хувь нь шинэ ном унших боломж, 16,4 хувь нь ажил, гэрийн даалгавар хийх орчин гэж хардаг байна. Гэхдээ номын сангийн үйлчилгээний чанарыг онцлон үздэггүй ажээ. Тэдний 5.3 хувь нь номын санд очиж байгаагүй гэж хариулсан нь сонин бөгөөд энэ нь зөвхөн нийтийн номын сангийн хувьд нэрлэсэн гэж үзэж байна.


Уншигч номын санг зорих гол шалтгаан бол мэдлэг, мэдээллийн эх сурвалж хайх, өөрт байхгүй байгаа номоо унших, эсвэл тав тухтай орчинд унших хүсэл юм.

График 16. Номын санд очдог шалтгаан




Нийт оролцогчдын 61.2 хувь нь сард 1-2 ном уншдаг бол, 17 хувь нь нэг ном дуусгаж амждаггүй гэсэн байна. Эндээс үзвэл манай судалгаанд уншигч хэмээгдэх шалгуур хангасан оролцогчид хамрагдсан байна.

График 17. Сард уншдаг номын тоо



Эмэгтэйчүүд төлөвлөсөн цагтаа ном уншиж чадахгүйд хүргэдэг гол хүчин зүйл нь ажлын цаг, гэрийн ажил, орчин болно. Монгол эмэгтэйчүүд өдөрт дунджаар 4.6 цагийг гэрийн ажилд зарцуулдаг болно.

График 18. Төлөвлөсөн цагт номоо уншиж чаддаггүй бол юу их нөлөөлж байна вэ?



Охид сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд хөвгүүдээс бага цаг зарцуулдаг бөгөөд энэ нь насанд хүрсэн ч үргэлжилдэг нь батлагдсан. Хөвгүүд гэрийн ажилд өдөрт 1 цаг 30 минут, охид 2 цаг 20 минут зарцуулдаг байна.¹³

Ном унших цаг төлөвлөлтөд хамгийн их нөлөөлдөг зүйл нь ажлын цаг 33.6 хувь, гэрийн ажил 23.4 хувиар нөлөөлдөг гэж хариулсан байна.

¹³ Тодгэрэл С. Монгол эмэгтэйчүүд өдөрт дунджаар 4.6 цагийг гэрийн ажилд зарцуулдаг. <https://peak.mn/news/news15185>. 2022.03.07.


НОМ УНШИХ АРГА

Судалгаанд оролцогчдын ном унших идэвхээ бууруулахгүй байх, бүтээлчээр уншихад 39.1 хувь нь өдөр бүр унших, 38.2 хувь нь төлөвлөж унших аргыг хэрэглэдэг гэжээ. Үүнээс ном унших дуртай эмэгтэйчүүдэд цаг байвал өдөр бүр уншихыг хүсдэг болох нь харагдаж байна. Энэ аргыг судалгаанд оролцогч ухамсартайгаар дадал болгоогүй ч чухалд тооцож байна гэсэн үг. Харин 31.2 хувь нь сэргээн харах аргыг сонгосон байна.

Экспертүүд номыг бүтээлчээр унших янз бүрийн аргуудыг уншигчдад зөвлөсөн байдаг. Жишээ нь, хэвлэлийн “Мөнхийн үсэг” ХХК-аас ном унших 4 аргыг нэрлэжээ. Үүнд: унших номоо ангилах, тэмдэглэл хөтлөх, хугацаа төлөвлөх, байнга ном авч явах.

Судалгаанд оролцогчдын ном унших идэвхээ бууруулахгүй байх, 27.7 хувь бүтээлчээр уншихад хувь нь өдөр бүр унших, 27.1 хувь нь төлөвлөж унших аргыг хэрэглэдэг гэжээ. Үүнээс мөн ном унших дуртай эмэгтэйчүүдэд цаг байвал өдөр бүр уншихыг хүсдэг болох нь харагдаж байна. Энэ аргыг судалгаанд оролцогч ухамсартайгаар өөрөө дадал болгоогүй ч чухалд тооцож байна гэсэн үг. Харин 22.1 хувь нь сэргээн харах аргыг сонгосон байна.

График 19. Номыг үр бүтээлтэй уншихын тулд ямар арга хэрэглэдэг вэ?




Судалгаанд оролцогчдоос 3 эмэгтэй “Анхаарлаа сайн төвлөрүүлж, аль болох нам гүм газар очдог”, “Төсөөлж унших”, “Бусдад уншсан зүйлээ ярих тайлбарлах” аргыг сонгодог гэж нэмж бичжээ.

Дараах зургаас “Эббинхаусын марталтын муруй”-г харж байна. Хүн ямарваа шинэ мэдээллийг хэр хугацаанд мартаж байна вэ? гэдгийг харуулсан муруй юм. Энэ муруйгаас харвал хүн 1 удаа л үзсэн хичээл, мэдээллийн 7-80%-ийг 1 өдрийн дараа гэхэд мартдаг. Гэхдээ 2, 3 дахь удаагийн уншилтаар мэдээлэл тархинд илүү удаан тогтдог. Тэгэхээр олон удаа давтан унших арга нь зүгээр нэг хичээл давтах арга гэхээсээ илүү судалгаагаар батлагдсан

найдвартай арга юм.¹⁴ Ном уншаад агуулгыг ойлгож ухаарах чухал, үндсэндээ ихэнхийг мартаx нь жам ёсны үзэгдэл гэдгийг энэхүү муруй баталж байна.

Зураг 4. Ebbinghaus-ын марталтын муруй



Эх сурвалж: <https://www.mindtools.com/pages/article/forgetting-curve.htm>.

Судалгаанд оролцогчдоос 3 эмэгтэй “Анхаарлаа сайн төвлөрүүлж, аль болох нам гүм газар очдог”, “Төсөөлж унших”, “Бусдад уншсан зүйлээ ярих тайлбарлах” аргыг сонгодог гэж нэмж бичжээ.

Дэлхийн хаана хүмүүс ном уншихад хамгийн их цаг зарцуулдаг вэ? Дэлхийн улс орнууд хэр их ном уншдаг талаар олон улсын соёлын чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэдэг “NOP” 2016 оны байдлаар долоо хоногт ном уншихад хамгийн их цаг зарцуулдаг иргэдтэй 30 улсыг гаргаж ирсэн. Тус жагсаалтыг БНЭУ тэргүүлсэн ба долоо хоногт Энэтхэгийн иргэд дунджаар 10 цаг 42 минутыг ном уншихад зарцуулдаг гэсэн тооцоо гарсан байна. Дараагаар нь Тайландын иргэд есөн цаг 24 минут, БНХАУ-ын иргэд 8 цагийг долоо хоногт тус тус зарцуулдаг аж.¹⁵ Эдгээр жагсаалтад орсон 30 улсын дийлэнх нь улс үндэстний түүх, соёлын арвин түүхтэй, аж үйлдвэржсэн, хүн амын тоо их учир хувь хүний өрсөлдөөн ихтэй орнууд. Харин манай улсын иргэдийн талаарх мэдээлэл олон улсын судалгаа, баримтуудад багтаагүйгээс харахад ном уншихад тийм ч их цаг зарцуулдаггүй бололтой.

¹⁴ Токиогийн их сургуулийн оюутны “Унших арга”. <https://www.japan-center.mn/a/23076>. 2020.09.15.

¹⁵ Ном их уншдаг хүн амьдралын хүнд бэрх нөхцөлийг давж гарах сэтгэлийн тэнхээтэй болдог. <https://ikon.mn/n/1dsl>. 2022.03.26.

Зураг 5. Долоо хоногт ном уншихад зарцуулдаг цагийн судалгаа.



Эх сурвалж: <https://www.worldatlas.com/articles/the-countries-that-read-the-most.html>. 2022.03.26.

Монголчууд телевиз үзэх, сошиал сүлжээ ашиглах зэрэгт 2 цагийг зарцуулж байна. Гэтэл дасгал хөдөлгөөн хийхэд хоногт дөнгөж 6 минут зарцуулдаг.¹⁶ Судалгаанд оролцогчдын ном унших болон нийгмийн сүлжээнд зарцуулж буй цагийг харьцуулан үзвэл.

Хүснэгт 2. Ном уншихад болон нийгмийн сүлжээнд зарцуулдаг цаг

Цаг	Ном уншихад өдөрт хэдэн цаг зарцуулдаг	Нийгмийн сүлжээнд өдөрт хэдэн цаг зарцуулдаг
1 цаг хүртэл	41.6%	22.7%
1-2 цаг	42.6%	34.4%
2-4 цаг	13.6%	26.6%
4-өөс дээш цаг	2.2%	17.4%


Монгол Улсад борлогддог нийт номын 30 гаруй хувийг импортын ном эзэлдэг. Үүнд гадаад хэл дээрх номоос гадна, гадаад улсад монгол хэл дээр хэвлэгдсэн ном багтдаг байна. Хүмүүс уншдаг төрлийн номоо цаашид давтан худалдан авах хандлагатай байдаг. Жишээлбэл, уран зохиолын ном уншдаг бол дараагийн удаа ч мөн уран зохиолын ном сонгодог байна.¹⁷

¹⁶ Монгол эмэгтэйчүүд өдөрт дунджаар 4.6 цагийг гэрийн ажилд зарцуулдаг. <https://peak.mn/news/news15185>. 2022.03.26.

¹⁷ Монголчуудын өрхийн орлого нэмэгдэх тусам ном худалдан авах нь ихсэж байна. <https://peak.mn/news/sudalgaa-mongolchuudiin-urkhiin-orlogo-nemegdekh-tusam-nom-khudaldan-awakh-ni-ikhsej-baina>. 2021.02.24.

Судалгаанд оролцогчид 25.4 хувь нь Орос, 19.7 хувь нь Англи, 17.8 хувь нь Америкийн зохиолчдын номыг унших дуртай гэж хариулсан байна. Урд хөршийн зохиолчдын ном нэлээд орчуулагдаж буй ч өрнөдийн орнуудын номыг сонгох хандлагатай нь харагдлаа. Монголын зохиолчдын номыг уншдаг гэж хариулсан. Үүнд олон улсын харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээ, манай улсын номын сангийн талаарх бодлогын нөлөөг анхаарч үзэх ёстой. Бусад гэсэн хариултад Турк, Швед, Энэтхэг, Испани, Төвөдийн уран зохиол уншдаг гэжээ.

График 20. Та гадаадын аль орны зохиогчдын ном бүтээлийг унших дуртай вэ?



“Номын ач цаглашгүй” хэмээдэг. Судалгаанд оролцогчид ном уншихын ач тусыг тодруулах асуултын үзүүлэлтэд жигд хариулт өгсөн байна. Тэд номын олон талын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсөн нийтлэг хандлага ажиглагдав. Эдгээрээс чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхийн ач холбогдлыг илүү онцолжээ.


Өндөр хөгжилтэй гаднын улс оронд зүрх судасны, эсвэл сэтгэл зүйн асуудалтай хүмүүст “Библиотерапи”¹⁸ гэх эмчилгээг сэтгэл судлалын мэргэжилтнүүд сүүлийн үед санал болгох болжээ. Манай судалгааны оролцогчдын 15 хувь нь ном унших сэтгэл санааг тайвшруулна гэж хариулсан байна. Энэ арга нь өвчтөн тулгамдаж буй асуудал, эсвэл сэтгэл санаа, биеийн тогтворгүй байдлын талаар эмчдээ хэлэхэд эмч тухайн нөхцөл байдалд таарсан хэд хэдэн номыг сонгон өвчтөнд санал болгодог байна. Тухайлбал, уран зохиолын ном нь та бидний бодож байгаагаас хавьгүй хүчтэй ба бусад хүмүүсийг ойлгож, өөрт тулгарч буй асуудлыг олон талаас эргэн харж, эргэцүүлэхэд тусалдаг тул олон улсын зарим судлаач номоор дамжуулж өвчтөнөө эмчлэх эл аргыг ашигладаг болсон түүхтэй аж. Номын эмчилгээнд шинжлэх ухааны алдартай уран зохиол (жишээлбэл, сэтгэл зүйн эмчилгээний тухай ном), уран зохиол хоёуланг нь ашиглаж болно. Номын санч үйлчлүүлэгчдэд гол сэдэв нь

¹⁸ Ном эмчилгээ (лат. biblio - ном, гр. therapia - эмчилгээ) гэдэг нь уран зохиолыг үгээр эмчлэх нэг хэлбэр болгон ашигладаг сэтгэл зүйн эмчилгээний арга.

тодорхой сэдэвтэй номуудыг санал болгодог. Тус номоос олж авсан мэдрэхүйн туршлага нь өөрийн туршлагагүй байдлаа нөхдөгт эмчилгээний үр нөлөө оршдог. Өөрөөр хэлбэл, хүн аливаа асуудлыг шийдвэрлэх шинэ боломж, арга замыг олоход тусалдаг шинэ бодол, хүсэл, дүр төрх, санааг олж авдаг.


Ном уншигчийн хэв маягийг янз бүрийн шалгуураар ангилсан байдаг. Тухайлбал, далд уншигчид, анхаарч уншигч, эргэцүүлэгч уншигч, стратегийн уншигчид.

График 21. Уншигчийн хэв маяг



Төрсөн өдөр, тэмдэглэлт өдрүүдэд бие биедээ ном бэлэглэдэг гэж олонх нь хариулсан байна. Мөн номын баяр, номын дэлгүүрүүдийн хямдралын үеэр борлуулалт илүүтэй байдаг нь монголчуудын номд дурлах хүсэл нэмэгдэж буйн илрэл юм. Худалдан авч буй номын дийлэнх нь түүхийн болон уран зохиолын сэдэвтэй номууд байдаг байна. Хүүхдийн болон танин мэдэхүйн, баримтат бүтээлүүд мөн эрэлттэйд тооцогддог аж.

График 22. Бусад ном бэлэглэх тохиолдол



Мөн судалгаанд оролцогчид “эрдэм ном эрхэмлэдэг хүнд, Бусдад туслахыг хүссэн үедээ баярт өдөр гэлтгүй ном бэлэглэдэг, бүх цаг үед ном бэлэглэдэг, Ер нь л ном бэлэглэх дуртай, тухайн хүнд хэрэгцээт ном, Боломж байвал найз нөхөд, зохион байгуулсан ажлын хүрээнд хүүхэд урамшуулах үед, Бэлэглэх боломж олдсон, эсвэл уншаасай гэж боддог номоо бэлэглэдэг. Бас хүүхдэдээ авмаар байгаа номыг нь хэзээ ч хамаагүй авч өгдөг, Хэрэгтэй үед эсвэл уншаад дууссан номоо бэлэглэдэг, Нийтээр зохион байгуулах ажилд ном




бэлгэлэх арга хэмжээнд ном бэлэглэсэн, Амжилт гаргасан үед, Тэмцээн уралдааны оролцогчдод” ном бэлэглэдэг гэж хариулсан нь тэдний ном бэлэглэх сэдлийг илэрхийлж байна.

Эх сурвалж: Үндэсний номын баяр орон даяар 18 өдөр үргэлжилнэ.
<https://gogo.mn/r/oyiqj>. 2021-09-19.

Судалгаанд оролцогчдын 73 хувь нь Монголд номын соёлын түвшин дунд зэрэг гэсэн бол ердөө 17 хувь нь сайн гэж үзжээ. Сүүлийн үед ном хэвлэх, борлуулах, унших хандлага нэмэгдэж буй. Үүнд нөлөөлж буй томоохон арга хэмжээ бол “Номын соёлт ертөнц” ТББ-аас 30 дахь удаа жил бүрийн хавар, намар зохион байгуулдаг. 2021 оноос УИХ-аас нийтээр тэмдэглэх ёстой 15 өдрийн нэг болгон хуульчилж, жил бүрийн 5, 9 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлэхээр болсон нь нийт уншигчдад эерэг нөлөө үзүүлнэ.

График 23. Номын соёлын түвшин



Судалгаанд оролцогчдын 73 хувь нь Монголд номын соёлын түвшин дунд зэрэг гэсэн бол ердөө 17 хувь нь сайн гэж үзжээ. Сүүлийн үед ном хэвлэх, борлуулах, унших хандлага нэмэгдэж буй. Үүнд нөлөөлж буй томоохон арга хэмжээ бол “Номын соёлт ертөнц” ТББ-аас **30 дахь удаа** жил бүрийн хавар, намар зохион байгуулдаг. 2021 оноос УИХ-аас нийтээр тэмдэглэх ёстой 15 өдрийн нэг болгон хуульчилж, жил бүрийн 5, 9 дүгээр сард тэмдэглэн өнгөрүүлэхээр болсон. Ном эрхлэн гаргагчид маань энэ удаагийн үзэсгэлэн худалдаанд уншигчдадаа зориулан номоо 10-50 хувийн хямралтайгаар борлуулдаг.

Түүнчлэн Үндэсний номын баярыг хөдөө орон нутагт зохион байгуулдаг болоод байна. 2021 онд Говь-Алтай аймагт өдөр бүр ном уншдаг больё гэсэн уриалгыг дэвшүүлэн “Оюунлаг Алтайчууд Номын баяр” үйл ажиллагааг зохион байгуулж, Улаанбаатар хотод трэнд болж байгаа номын үзэсгэлэнг дэлгэснээс гадна утга зохиол, нийгмийн ажилтан, номын санч, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, төрийн байгууллагын зарим албан хаагчдад чиглэсэн олон төрлийн сургалт-уулзалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа өрнүүлсэн байна.¹⁹

Эмэгтэйчүүдийн ном унших асуудлыг яагаад дэмжин сурталчлах хэрэгтэй вэ? Ядуурлыг бууруулах Япон сан, АХБ-аас “Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендерийн дүн шинжилгээ” хэмээх судалгааны тайланд “Залуу малчдын нийгэм-соёлын үйлчилгээнд хамрагдалтыг тодруулахад судлагдсан малчдын 50 гаруй хувь нь үйлчилгээг авахад хүндрэлтэй байдаг аж. Хамгийн хүндрэлтэй үйлчилгээнд халуун усанд орох (62.1 хувь) сонирхсон номоо худалдан авах (58.3 хувь), үзвэр үзэх (54.2 хувь) зэргийг дурджээ. Судлагдсан 10 залуу малчны нэг нь ч номын сангаар үйлчлүүлж үзээгүй, 4 хувь нь сонирхсон номоо худалдаж авч үзээгүй байна. Эрэгтэй залуу малчдыг бодвол эмэгтэй залуу малчдын 65.2 хувь халуун усанд ороход, 60.8 хувь нь сонирхсон номоо худалдаж авахад хүндрэлтэй байдаг. Залуу малчдыг явуулын номын сангаар үйлчлэх, соёл урлагийн үзвэр үйлчилгээгээ хангах, уулзалт, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг малчдыг хөгжих, эвлэлдэн нэгдэх, мэдээллээр хангах цогц соён гэгээрлийн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна. Үүнээс харахад залуу малчдад хамгийн хэрэгцээтэй байгаа үйлчилгээнүүдийн хүртээмж тааруу байгааг судалгаанд оролцогчид илэрхийлсэн. Сум орон нутгийн удирдлага сумын соёлын клубтэйгээ хамтран залуу малчдад хэрэгцээтэй байгаа үдэшлэг, нийтийн бүжиг, арга хэмжээг зохион байгуулах, явуулын номын сангаар үйлчлэх, үзвэр үйлчилгээгээр хангах, уулзалт, зөвлөгөөн, тэмцээн уралдаан зохион байгуулах зэргээр залуу малчдыг хөгжих, эвлэлдэн нэгдэх, мэдээллээр хангах цогц соён гэгээрлийн үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байна” хэмээн тэмдэглэсэн нь манай судалгаатай холбогдож байна.

Эмэгтэйчүүд амьдралд нь томоохон өөрчлөлт авчирсан нэг номын төрөлд уран зохиолын номыг ихэвчлэн нэрлэсэн байна. Үүнд монголын болон гадаадын нэрт зохиолчдын сонгодог бүтээлүүдийг дурджээ.

¹⁹ Б.Сувд: Хүүхэд, залуучуудын ном унших хүсэл, хэрэгцээ их байна. 2021.11.01.


График 24. Амьдралд нь томоохон өөрчлөлт авчирсан нэг номын төрөл




Хүснэгт 3. Тухайн номын зохиолч ба номын нэрийг бичнэ үү.

Монгол зохиолчид	Гадаадын зохиолчид
Д.Нацагдорж. Цагаан сар ба хар нулимс Л.Түдэв. Хорвоотой танилцсан түүх, Хувь тавилан С.Эрдэнэ. Холбоо гурван тууж, Занабазар Ж.Пүрэв. Манан будан Ч.Лодойдамба. Тунгалаг тамир Д.Маам. Элс цас Д.Батбаяр. Тэнгэрийн улаач Р.Чойном. Хүн Б.Лхагвасүрэн. Хүнд манан, Шүлгийн түүвэр Г.Мэнд-Ооёо. Гэгээнтэн Б.Сарантуяа. Сорхугтани Б.Шүүдэрцэцэг. Хотолун гүнж, Ану хатан, Самар хатан Ц.Оюунгэрэл. Ногоон нүдэн лам Л.Өлзийтөгс. Үзэхийн хязгаар, Хараацай зогсолт Лха.Дарьсүрэн. Онцгой эрх Х.Болор-Эрдэнэ. Гүйж яваа эмэгтэй г.м	Чингиз Айтматов. Анхны багш Теодар Драйзер. Керри эгч Жек Лондон. Мартин Иден Майн Рид. Хурлийз бүсгүй Г.Маркес. Зуун жилийн ганцаардал А. Дюма. Монте Кристо гүн Нанак Сингх. Сундари Габриэл Верн Жюль. Усан доогуур 20000 бээр аялсан нь Марк Твэйн. Жанна Д Арк Мүраками Харүки. Норвегийн ой Д.Дефо. Робинзон Крузо Брээм Чанд. Ядуугийн зовлон г.м

Сүүлийн үед эмэгтэйчүүд хувь хүний хөгжлийн номыг нэлээд сонирхон уншиж буй нь ажиглагдлаа. Тухайлбал, “В.Вүүлф. Өөрийн гэсэн өрөө, И Жи Сонг.



Б.Коркоран: Бүсгүйн код, Нам Ик Сү. Бүсгүй та эргэлзэлгүй яв, Юлия Борисовна Гиппенрейтер. Хүүхэдтэй хэрхэн яаж Зөв харьцах вэ?” зэргийг нэрлэж байна.



Номонд дурлагсдын хувьд тохь тухтай номын санд суугаад номоо унших нь чухал юм. Тиймээс хичээл, ажлынхаа заваар ном уншиж, хөгжим сонсож, хөгжөөнт тоглоом тоглох зэргээр чөлөөт цагаа илүү бүтээлчээр өнгөрүүлж болох хүн бүхэнд нээлттэй номын сангууд бий болж байна. Тухайлбал, 2019 онд МУИС цагийн номын санг Монголд анх удаа байгуулсан.

2022 оны 3-р сарын 14-өөс МУИС-ийн Номын сан оюутнууддаа 24 цагаар тогтмол үйлчилгээ үзүүлдэг болгох шийдвэр гаргасан. Номын сан нь шалгалтын үеэр 24 цагаар үйлчилгээ үзүүлдэг байсан бол 2022 оны гуравдугаар сарын 21-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 24 цагийн уншлагын танхимыг туршилтаар нээж ажиллуулахаар болжээ. Тус сургуулийн шинэ номын сан 360,000 гаруй хэвлэмэл болон цахим ном, сонин, сэтгүүлийн сан хөмрөгтэй. 1,000 орчим CD, зохиогчийн эрхтэй 20 гаруй цахим ном, 2,000 орчим магистрын ажил, ОУ-ын 16 онлайн мэдээллийн санг ашиглах боломжтой цахим уншлагын танхимтай юм байна.

Уншигчдад зориулсан ийм тав тухтай үйлчилгээ нь цаашид улам нэмэгдэх шаардлагатай нь манай судалгаанд оролцогчдын хариултаас харагдаж байна.



Эх сурвалж: 2021 он. Төв талбайд болж буй Үндэсний номын баяр.
<https://ikom.mn/n/28wh.html>

ДҮГНЭЛТ

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх олонх нь дээд боловсролтой эмэгтэйчүүд байв. Тэдний 50 хувь нь 15 хүртэл насандаа номд дур сонирхолтой болсон бөгөөд ном сонирхон унших сонголт, дадалд гэр бүлийнхэн, найз нөхөд нөлөөлсөн байгаа нь ойр дотнын хүнээс хамааралтай амьдардаг монголчуудын сэтгэл зүйн илрэл болно.

Өнөөгийн эмэгтэйчүүд хувь хүний хөгжил, нэрт хүмүүсийн намтар, уран зохиолын номыг шимтэн сонирхож байна. Энэ нь дэлхийн уншигчдын нийтлэг үзэгдэл хэдий ч эмэгтэйчүүд амьдралын бодит туршлага, зөвлөмж бүхий номыг илүү их сонирхдог байна. Харин уран зохиолын номын сонголтод сонгодог уран зохиол, монгол роман, тууж зонхилж, орчин цагийн сонсдог номын хэрэглээ бага байна. Номын сонголтод монгол зохиолчдын ном давамгайлах боловч европын ном зохиолыг илүү сонирхдог байна. Энэ нь хэвлэн нийтлэгчдийн борлуулж буй номоос хамаарах боловч тэд маркетингийн судалгаанд үндэслэж ямар орны ямар ном орчуулж хэвлэхийг нарийн тооцож буй.


Улсын хэмжээнд 1500 гаруй номын сан үйл ажиллагаа явуулж буй боловч эмэгтэйчүүд ажил, гэрийн даалгавар хийх зайлшгүй шаардлагаар номын санг зорьдог ч өөрийн чөлөөт цагийн байдлаас хамаарч аль болох гэртээ, элдэв ажилд сатаарахгүй оройн цагаар ном уншихад таатай орчин бүрддэг байна. Эндээс үзвэл эмэгтэйчүүдийн унших соёлыг нэмэгдүүлэхийн тулд зөөврийн номын санг хөгжүүлэх шаардлага байж болно. Ажлын газар, сургуулийн номын сан гэсэн өөрт ойр, цаг хэмнэсэн орон зайд орших номын санг эмэгтэйчүүд сонгон үйлчлүүлэх магадлалтай.

Судалгаанд оролцогчид номын сангийн хүрэлцээ, номын соёлын түвшинг дунд зэрэг үнэлж буй юм. Иймээс 1. Номын сангийн өнөөгийн байдалд бодитой дүн шинжилгээ хийх; 2. Уншигчдын судалгааг тодорхой хугацаанд, тасралтгүй хийх, дүгнэх; 3. Судалгааны үндсэн дээр өөрсдийн сайн чадах, боломжит ажлуудыг уншигчдад санал болгох; 4. Шинэ арга, технологи нэвтрүүлэхдээ ажилтнуудыг сургах, хөгжүүлэх; 5. Үйлчилгээний нэр төрөл, тоонд бус, харин чанарт анхаарах; 6. Тав тухтай орчныг бүрдүүлж байнгын уншигчдаа татах; 7. Сан хөмрөгийн баяжилтад анхаарах шаардлагатай. Номын сангууд үйлчилгээний хүртээмж болон “чанартай” уншигчийн тоог нэмэгдүүлэхийн тулд уншигчдадаа чиглэсэн, чухал, хэрэгцээтэй гэсэн үйлчилгээг санал болгох нь зүйтэй. Уншигчид, орон нутгийн онцлогийг харгалзан үйлчилгээнийхээ нэр төрлийг зохистой түвшинд барьж, харин чанарыг нэмэгдүүлэхэд анхаарч чадвал үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.²⁰ Номын сангийн зорилго нь өөрийн үүргийн дагуу “өөрт хамаарах” хүн бүрийг уншигч болгох үүрэгтэй байгууллага тул цаашид танхимын болон цахим уншигчийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах нь чухал юм.

Тус судалгааны үр дүн нь эмэгтэйчүүд болон жендер судлал, ном судлал, номын худалдаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжүүдийн практик үйл ажиллагаанд ашиглах санал зөвлөмж боловсруулах, хэвлэлийн компанийн маркетинг, номын

²⁰ Хайдав Т. Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд үйлчилгээний нэр төрөл нөлөөлөх нь үндсэн асуудал: <https://pdfcoffee.com/--8526-pdf-free.html>. 2022.03.19.

сангийн үйлчилгээг сайжруулах, төрөөс эмэгтэйчүүд, соёлын талаар баримтлах бодлогод нөлөөлөх ач холбогдолтой гэж үзэж байна.



Ном зүй

1. Oxford. Dictionary of academic English. OXU., 2018.
2. “Өнөөгийн монгол эмэгтэй уншигчийн хандлага” сэдэвт социологийн судалгааны тайлан. УБ.,2022.

Цахим эх сурвалж:

3. Монголчуудын өрхийн орлого нэмэгдэх тусам ном худалдан авах нь ихсэж байна. <https://peak.mn/news/sudalгаа-mongolchuudiin-urkhiin-orlogo-nemegdekh-tusam-nom-khudaldan-awakh-ni-ikhsej-baina>. 2021.02.24.
4. Монголчууд хоногт дунджаар 9.2 цаг унтаж, 3.3 цаг ажил хийж, 6 минут спортоор хичээллэж байна. <https://ikon.mn/n/1yif>. 2022.03.26.
5. Монгол эмэгтэйчүүд өдөрт дунджаар 4.6 цагийг гэрийн ажилд зарцуулдаг. <https://peak.mn/news/news15185>. 2022.03.26.
6. Ном их уншдаг хүн амьдралын хүнд бэрх нөхцөлийг давж гарах сэтгэлийн тэнхээтэй болдог. <https://ikon.mn/n/1dsl>. 2022.03.26.
7. Сонирхолгүй ном гэж үгүй. <http://eagle.mn/r/99108>. 2022.03.10.
8. Тодгэрэл С. Монгол эмэгтэйчүүд өдөрт дунджаар 4.6 цагийг гэрийн ажилд зарцуулдаг. <https://peak.mn/news/news15185>. 2022.03.07.